

## СҮМБЭР СУМЫН 2023 ОНЫ ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ БАРАГДУУЛАЛТЫН ТАЙЛАН

2023.09.15

Сүмбэр

2023 оны 09 сарын 15-ны өдрийн байдлаар Сумын Засаг даргад нийт- 132 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирсэн.

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас сумын Засаг дарга, Тамгын газарт хандаж ирүүлсэн өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариуг тухай бүр өгч ажиллалаа.

Ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг агуулгаар нь авч үзвэл:

- Асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоолгох, хүүхэд үрчлэх, тухай - 19
- Хандив, буцалтгүй тусламж, тоног төхөөрөмж хүссэн - 6
- Тусгай зөвшөөрөл /тамхи/ - 7
- Худаг усны асуудлаар- 3
- Газрын асуудлаар- 77
- Хог хаягдалын асуудлаар – 3
- Тоглоомын газар нээх хүсэлт-2
- Модны асуудлаар – 4
- Байгаль орчны үнэлгээ хийлгэх – 2
- Үнэлгээ тогтоох хүсэлт - 2
- Бусад-7

Сумын Засаг дарга болон газрын даамалд газар эзэмших, ашиглах, өмчлөх хүсэлтээр 77 өргөдөл ирсэн ба 33 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж, 12 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна. Мөн 32 өргөдлийг ИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлэхээр төлөвлөн ажиллаж хугацааг сунгасан байна.

“Гэр бүлийн тухай хууль”-ийн дагуу эрүүл мэндийн байдал болон өндөр настай болсны улмаас иргэний эрх, үүргээ биечлэн хэрэгжүүлэх боломжгүй болсон 17 иргэнд асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосон сумын Засаг даргын захирамж гарган, хүүхэд үрчлэх 2 хүсэлтийг хамтарсан багийн хурлаар шийдвэрлэсэн. Мөнгөн тусламж хүссэн 3 иргэнд нийт **1,900,000** төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. /Цусны хавдартай хүүхдийн эмчилгээнд-1.000.000 төгрөг, Морин өртөө уралдаанд 500.000 төгрөг, БНСУ руу тэмцээнд оролцоход-400.000 төгрөг/ Мөн

“Жанжин чойр” бүжгийн хамтлагийн 3 иргэнээс ОУ-ын тэмцээнд явахад нь дэмжлэг үзүүлэх тухай өргөдөл ирсэнийг “Жанжин чойр” бүжгийн хамтлагт 3.000.00 төгрөгийн дэмжлэг үзүүлж шийдвэрлэсэн. 7 сард хүчтэй аадар борооноор үерт автаж орон гэргүй болсон 3 иргэний өргөдлийг боломжгүй гэж хариуг утсаар мэдэгдсэн ба орон гэргүй иргэний судалгаанд бүртгэн авч шийдвэрлэлээ.

Тамхины тусгай зөвшөөрөл хүссэн 7 иргэний 6 өргөдөлийг хугацаанд нь шийдвэрлэж 1 иргэний өргөдөл материал дугуу учраас буцаагдсан байна. Мөн РС тоглоомын газар ажиллуурах хүсэлтийн материалыг Дорноговь аймгийн СХЗ-д хүргүүлэн хариу ирсэж тус өргөдлүүдийг шийдвэрлэсэн.

Хог хаягдлыг цэвэрлэх тухай 3 өргөдлийн иргэдтэй багийн Засаг дарга, байгаль орчны мэргэжилтэн нар биечлэн уулзаж хог хаягдлыг цэвэрлэж шийдвэрлэсэн байна.


Модны урамшуулал хүссэн 4 иргэний өргөдлийг шийдвэрлэхээр мод тооллогын ажил хийгдэж байна.

Байгаль орчны үнэлгээ хийлгэх 2 иргэний хүсэлтийг дэмжин тодорхойлолт гаргаж хугацаанд нь шийдвэрсэн. Мөн худаг гаргах 3 иргэний хүсэлтийн 2 өргөдийг дэмжиж 1 иргэний хүсэлтийг буцаасан байна.

Нийт 132 өргөдлөөс 91 өргөдөл бүрэн шийдвэрлэж 70%-ийн гүйцэтгэлтэй байна.

ТАЙЛАН БИЧСЭН:  
МТОНХ АЖИЛТАН

ХЯНАСАН:  
ЗТДГ-ЫН ДАРГА



Ч.УНДАРМАА

П.НАРАНМАНДАХ

2023.09 сар

Иргэдээс Сүмбэр суманд хандаж ирүүлсэн өргөдөл,  
гомдол, санал хүсэлт шийдвэрлэлтийн байдал

Сүмбэр

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт /хувь/
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа сунгасан	Хугацаа болоогүй	
1	Сүмбэр сум	132	91		36	5	70%
	Нийт	132	91		36	5	70%

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийн тоо	Үүнээс						Бусад /иргэдтэй ажиллах-нээлттэй өдөрлөгөөр
			Бичгээр	Амаар	11-11 төвөөр	Цахим хэлбэрээр	Утсаар 70543232	Биечлэн уулзсан /амаар/	
1	Сүмбэр сум	132							
	Нийт	132							

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/	
		1	Сүмбэр сум
		Хандив, мөнгөн тусламж хүссэн-6	4.5%
		Тусгай зөвшөөрөл - 7	5.3%
		Худаг усны асуудлаар- 3	2.3%
		Газрын асуудлаар- 77	58.3%
		Хог хаягдалаар - 3	2.3%
		Тоглоомын газар нээх хүсэлт - 2	1.5%
		Модны асуудлаар-4	3%
		Байгаль орчны үнэлгээ хийх - 2	1.5%
		Үнэлгээ тогтоох хүсэлт - 2	1.5%
		Бусад-7	5.3%

Мэдээ гаргасан: МТОНХ ажилтан

Хянасан:

Засаг даргын Тамгын газрын дарга

Ч.Ундармаа

П.Наранмандах

